



ИНД-26

Иргэний Нисэхийн Багц Дүрэм

Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага

Иргэний нисэхийн ерөнхий газар

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-26 нь бусад дүрмүүдэд заагдсан нислэгт тэнцэх чадварын шаардлагаас гадна, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагыг тогтооно.

Энэ Дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан ИНД-26-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-26, түүний нэмэлт, өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн Дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг Дүрмийн зохицуулалтад шилжих Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-нд байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн энэхүү багц Дүрмийг боловсруулсан.

Өөрчлөлтийн түүх**Хүчин төгөлдөр огноо**

Анхны боловсруулалт

2003 оны 02 сарын 01

Нэмэлт, өөрчлөлт 1

2010 оны 06 сарын 25

Нэмэлт, өөрчлөлт 2 (Шинэчлэлт)

2018 оны ... сарын...

Тэмдэглэл: ИНД-26-ийн шинэчлэлтийг англи болон монгол хэл дээр, NZ Part 26 А.2-т үндэслэн боловсруулсан болно.

Гарчиг

А Бүлэг — Ерөнхий зүйл	5
26.1. Зорилго	5
В Бүлэг — Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага	5
26.51. Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага	5
26.53. Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагын хамаарал	5
Хавсралт А — Нөөц	6
Хавсралт В — Бүх агаарын хөлөг	6
В.1. Хаалга болон ослын гарцны тэмдэглэгээ	6
В.2. Багийн хамгаалалтын шаардлага	6
Хавсралт С — Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 9-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоц	6
С.1. Хаалга болон гарц	6
С.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц	7
С.3. Систем болон тоног төхөөрөмж	8
Хавсралт D — Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 19-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоц	8
D.1. Хаалга болон гарц	8
D.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц	9
D.3. Ариун цэврийн өрөөний галын хамгаалалт	13
D.4. Бүхээгийн доторлогооны материал	13
D.5. Ачаа болон тээшний бүхээг	14
Хавсралт E — Нисдэг тэрэг	15
E.1. Хаалга болон гарц	15
E.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц	15

А Бүлэг — Ерөнхий зүйл

26.1. Зорилго

Энэ Дүрэм нь аливаа бусад дүрэмд тусгасан нислэгт тэнцэх чадварын шаардлагаас гадна, Монгол Улсын бүртгэлтэй агаарын хөлөгт тавих нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагыг тогтооно.

В Бүлэг — Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага

26.51. Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлага

ИНД-21-д заасан Нислэгт тэнцэх чадвар (цаашид НТЧ гэх)-ын нэмэлт шаардлага нь энэ Дүрмийн дараах хавсралтад тусгагдсан:

- (1) Хавсралт В - бүх агаарын хөлөгт;
- (2) Хавсралт С - маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 9-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоцонд;
- (3) Хавсралт D - маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 19-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоцонд;
- (4) Хавсралт E - нисдэг тэргэнд.

26.53. Нислэгт тэнцэх чадварын нэмэлт шаардлагын хамаарал

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, зөвхөн тухайн заагдсан ангилал, категори, эсхүл агаарын хөлгийн маяг, эсхүл бүрдэл хэсэгт тавих 26.51-д тусгасан НТЧ-ын нэмэлт шаардлагыг дараах этгээд хангах үүрэгтэй:

- (1) НТЧ-ын гэрчилгээ эзэмших хүсэлт гаргагч;
- (2) ИНД-21.505-ын дагуу техникийн өгөгдөхүүний зөвшөөрлийн хүсэлт гаргагч;
- (3) Монгол Улсын бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч.

(b) Аливаа НТЧ-ын хангагдаагүй нэмэлт шаардлагыг Даргын хүлээн зөвшөөрөхүйц, аюулгүй байдлын дүйцэх түвшний хүчин зүйлээр нөхсөн байх шаардлагатай.

(c) Энэ Дүрмийн НТЧ-ын нэмэлт шаардлагыг хангах шаардлагатай хэрэгсэл болон тоног төхөөрөмж нь агаарын хөлгийн үйлдвэрлэгчийн зааварчилгаа, эсхүл Даргын хүлээн зөвшөөрөхүйц бусад холбогдох зааварчилгааны дагуу суурилуулсан байх ба ИНД-91.539-ийн дагуу тухайн агаарын хөлгийн MEL-д өөрөөр зөвшөөрснөөс бусад тохиолдолд, бүрэн ажиллагаатай байх шаардлагатай.

Хавсралт А — Нөөц

Хавсралт В — Бүх агаарын хөлөг

Агаарын хөлгийн гэрчилгээжүүлэлтийн нэмэлт НТЧ-ын шаардлага нь дараах зүйлийг агуулна:

В.1. Хаалга болон ослын гарцны тэмдэглэгээ

(а) Хэвийн болон ослын гарц тус бүрд ГАРЦ, эсхүл ОСЛЫН ГАРЦ гэсэн холбогдох тэмдэглэгээ болон нээх аргачлалыг дараах байдлаар, тод харагдахуйц хийсэн байна:

- (1) тухайн гарцны дотор болон гадна хоёр талд; эсхүл
- (2) тухайн агаарын хөлгийн дотор болон гадна талд, гарцны хажуу гадаргуу дээр.

(b) Энэ зүйлийн (а)-д шаардсан гарцыг ажиллуулах бүх зааварчилга нь:

- (1) товч тодорхой;
- (2) уншихад хялбар үсгээр, тод ялгарах дэвсгэр дээр байна.

В.2. Багийн хамгаалалтын шаардлага

Хөдөө аж ахуйн зориулалттай хязгаарлагдмал категориор гэрчилгээжих агаарын хөлөг нь 1965 оны 02 сарын 01-ээс хүчинтэй болсон АНУ-ын Civil Aeronautics Manual 8-ын Appendix В-ын Section.35-д тусгагдсан багийн хамгаалалтын шаардлагыг хангасан байна.

Хавсралт С — Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 9-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоц

Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 9-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоцны НТЧ-ын гэрчилгээжүүлэлтийн нэмэлт шаардлага нь Хавсралт В-ээс гадна дараах зүйлийг агуулна:

С.1. Хаалга болон гарц

Гадна хаалга болон гарц бүр нь:

- (1) нисэх багийн бүхээгийн гүйдэг цонхон гарцнаас бусад нь дотор болон гадна талаасаа нээгддэг байх;
- (2) сандал, сандлын түшлэг, эсхүл бусад төхөөрөмжөөр халхлагдаагүй байх;
- (3) дараах хэлбэрээр тоноглогдсон байх:
 - (i) нислэгийн үед аливаа этгээд, эсхүл механик гэмтлийн үр дүнд санаандгүй нээгдэхээс хамгаалсан түгжээтэй;

- (ii) тухайн хаалгыг нээх анхны хөдөлгөөн нь гадагш чиглэдэг бол, багийн гишүүд хаалга бүрэн хаагдсан болон түгжигдсэнийг тогтоох шууд харагдах түгжээний механизмтай;
- (iii) тухайн хаалгыг, онгоцны ачилт, буулгатад ашигладаг бол, тухайн хаалга бүрэн хаагдаагүй болон түгжигдээгүй нь багийн гишүүдэд ил харагдахаар байна.

С.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц

С.2.1. Ослын нэмэлт гарцууд

(a) Зорчигчдын орох хаалга нь 1993 оны 05 сарын 10-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR 23-ын шалны түвшний ослын гарцад тавих шаардлагыг хангасан байна.

(b) Онгоц бүр нь зорчигчдын орох хаалганаас гадна, дараах шаардлагыг хангасан нэмэлт ослын гарцаар тоноглогдсон байна:

- (1) маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 16-аас цөөн зорчигчтой онгоц нь их биеийн хоёр талдаа 1993 оны 05 сарын 10-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR 23.807(b)-ын шаардлагыг хангасан гарцтай байх; эсхүл
- (2) маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 16-аас 23 зорчигчтой онгоц нь:
 - (i) зорчигчдын орох хаалгатай талд нэмэгдэл нэг гарцтай байх;
 - (ii) зорчигчдын орох хаалганы эсрэг талд хоёр гарцтай байх, 1993 оны 05 сарын 10-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR 23.807(b)-ын шаардлагыг хангасан байх; эсхүл
- (3) маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 23-аас дээш зорчигчтой онгоц нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан гарцтай байна.

С.2.2. Ослын гарцны нүүлгэн гаргах тоног төхөөрөмж

Агаарын хөлгийн маягийн гэрчилгээжүүлэлтэд шаардлагатай ослын гарц бүр нь:

- (1) далавчны дээр байрласан; эсхүл
- (2) онгоц газарт дугуйгаа буулгасан байдалд гарц нь газраас дээш 2 м, эсхүл түүнээс дээш өндөрт байгаа бол бүхээг дэх хүмүүсийг газарт буулгахад туслах хэрэгсэлтэй байна.

С.2.3. Ослын гарцны дотор тэмдэглэгээ

Ослын гарц бүр нь дараах тэмдгээр танигддаг байх, энэ нь:

- (1) ГАРЦ /EXIT гэсэн үг байх ба:
 - (i) 25 мм өндөртэй цагаан өнгийн үсгээр, 50 мм-ийн өндөртэй улаан дэвсгэр дээр; эсхүл
 - (ii) 25 мм өндөртэй улаан өнгийн үсгээр, 50 мм-ийн өндөртэй цагаан дэвсгэр дээр бичсэн байх;

- (2) өөрөө гэрэлтдэг, эсхүл үндсэн гэрэлтүүлгийн системээс хамааралгүйгээр цахилгаанаар гэрэлтдэг байх;
- (3) минимум 160 микроламбер гэрлийн тодроцтой байх.

С.3. Систем болон тоног төхөөрөмж

С.3.1. Газардах ангийн анхааруулах дуут дохио

(a) Далавчны флапстай болон хураагддаг газардах ангитай онгоц нь газардах ангийн анхааруулах дуут дохионы хэрэгсэлтэй байна.

(b) Энэ зүйлийн (c)-д зааснаас бусад тохиолдолд, газардах ангийн анхааруулах дуут дохионы хэрэгсэл бүр нь:

- (1) буултын бэлтгэл үед далавчны флапсыг буултын үеийн хэвийн байрлалд буулгасан тохиолдолд газардах анги бүрэн бууж, түгжигдээгүй үед үргэлжлэн ажилладаг байх;
- (2) гар унтраалгагүй байх.

(c) Энэ зүйлийн (b)(2) нь газар-усны онгоцонд, тухайн агаарын хөлөг усан дээр буулт үйлдэх байдалд орсныг нисэх багийн гишүүдэд ил хараагаар, хангалттай харуулахаар тоноглогдсон бол хамаарахгүй.

Хавсралт D — Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 19-өөс дээш зорчигчтой агаарын тээврийн онгоц

Маягаар гэрчилгээжсэн суудлын багтаамж нь 19-өөс дээш зорчигчтой онгоцны гэрчилгээжүүлэлтийн нэмэлт НТЧ-ын шаардлага нь Хавсралт В болон Хавсралт С-д зааснаас гадна дараах зүйлийг агуулна:

D.1. Хаалга болон гарц

D.1.1. Гарцны төрлүүд

Гарцны төрлүүд нь 1993 оны 03 сарын 29-өөс хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.807-д заасны дагуу байна.

D.1.2. Шалны түвшний гарц

Зорчигчийн бүхээгээс нэвтрэх боломжгүй ачааны, эсхүл тээшний бүхээг рүү хөтлөх гарцнаас бусад, их биений хажуу талын шалны түвшний гарц бүр нь шалны түвшний ослын гарцны шаардлагыг хангасан байна. Хэрэв гарц нь:

- (1) 1090 мм-ээс өндөр, 490 мм-ээс 1150 мм-ийн хооронд өргөнтэй; эсхүл
- (2) өөхийн гарц; эсхүл
- (3) сүүлний нарийссан хэсгийн гарц бол.

D.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц

D.2.1. Нэмэлт ослын гарц

(a) Зорчигчийн бүхээг нь тухайн агаарын хөлгийн маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагаас илүү тооны ослын гарцтай бол тэдгээр нь:

- (1) энэ Хавсралтын холбогдох бүх шаардлагуудыг хангасан байх;
- (2) саадгүй хүрч болохоор байх.

(b) Турбо-жет хөдөлгүүрт онгоцны өөхийн болон сүүлний нарийссан хэсгийн гарцууд нь:

- (1) нислэгийн үед нээгдэхгүйгээр зохион бүтээгдэж, үйлдвэрлэгдсэн байх;
- (2) дараах зурагт хуудсаар тэмдэглэгдсэн байх:
 - (i) нислэгийн үед гарцыг нээж болохгүйг анхааруулсан;
 - (ii) 750 мм-ийн зайнаас уншигдахуйц;
 - (iii) тухайн гарцыг нээх хэрэгслийн ойр, тод харагдахуйц байрлалд суурилуулсан.

D.2.2. Ослын гарцанд хүрэх

(a) Нэмэлт ослын гарцаас бусад, онгоцны ослын гарцанд хүрэх боломжийг дараах байдлаар бататгасан байна:

- (1) дараах дамжин хүрэх зам бүр нь саадгүй бөгөөд 500 мм-ээс доошгүй өргөнтэй болохыг:
 - (i) зорчигчийн хэсэг тус бүрийн хооронд;
 - (ii) I, эсхүл II төрлийн ослын гарцанд хөтлөх зам;
- (2) I болон II төрлийн ослын гарцны орон зай нь багийн гишүүд замын саадгүй өргөнийг 500 мм-ээс бага болгохгүйгээр зорчигчдыг нүүлгэн гаргахад туслах хангалттай хажуугийн зайтай болохыг;
- (3) бүхээгийн үндсэн замаас III болон IV төрлийн гарц бүрд хүрэх зам нь гарцны нэвтрэх боломжийг багасгах суудал, тавиур, эсхүл бусад саадаар халхлагдаагүй болохыг;
- (4) зорчигчийн бүхээгийг ослын гарцнаас тусгаарлаж буй хаалга бүр нь дараах хэрэгсэлтэй болохыг:
 - (i) хөөрөлт болон буултын үед нээлттэй байдалд түгжих хэрэгсэлтэй байх ба энэ нь загварын гэрчилгээжүүлэлтийн стандартад заасны дагуу эргэн тойрны бүтцэд үйлчлэх нийт инерцийн хүчийг даах чадвартай;
 - (ii) хөөрөлт болон буултын үед хаалга нээлттэй байх ёстойг харуулсан зурагт хуудастай.

(b) Ослын гарцанд хүргэх зорчигчийн бүхээгийн хоорондох дамжин хүрэх зам бүр нь дамжин хүрэх замын дагуу чөлөөтэй нэвтрүүлэх боломжтой хөшигнөөс өөр саадгүй байна.

(с) Зорчигчийн бүхээг хоорондын тусгаарлагчид хаалга суурилуулж болохгүй.

D.2.3. Ослын гарцыг удирдах бариул

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд онгоц бүр, гарц бүрийн ойролцоо, эсхүл дээр дараах тэмдэглэгээтэй байна:

- (1) тэмдэглэгээ нь 750 мм-ийн зайнаас уншигдахуйц;
- (2) зорчигчийн ослын гарцыг удирдах бариул бүрийн байрлалын;
- (3) бариулын эргэх хөдөлгөөнөөр түгжээний механизм нь тайлагддаг I болон II төрлийн ослын гарцыг багтаасан гарцыг нээх зааварчилгаа нь:
 - (i) 20 мм-ээс багагүй өргөн иштэй, толгой нь ишнээсээ хоёр дахин өргөн, ойролцоогоор бариулын уртын дөрөвний гуравтай тэнцүү радиустай 70°-аас багагүй урт тойргийн нумтай улаан өнгийн сум;
 - (ii) сумны толгойн хажууд хэвтээ байрлуулсан 25 мм хэмжээтэй улаан өнгийн үсгээр бичсэн OPEN / НЭЭЛТТЭЙ гэсэн үгтэй байна.

(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагын дагуу тэмдэглэгээ хийсэн байна.

(с) Удирдах бариул болон удирдах бариулын бүрхүүл бүр нь минимум 100 микроламберт гэрлийн тодроцтой байна.

D.2.4. Ослын гарцны нүүлгэн гаргах тоног төхөөрөмж

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, ослын гарц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон шаардлагыг хангасан, бүхээг дэх хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэлтэй байх ёстой.

(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоцны хувьд, ослын гарц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, бүхээг дэх хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэлтэй байх ёстой.

(с) Энэ зүйлийн (а) болон (b)-д заасан, бүхээг дэх хүмүүсийг газарт буухад туслах хэрэгсэл нь хэрэв автоматаар дэлгэгддэг бол энэ нь явгалалт, хөөрөлт болон буултын үед бэлэн байдалд орох чадвартай байх шаардлагатай.

D.2.5. Ослын гарцны дайжих зам

(а) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, онгоц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон шаардлага хангасан, хальтирдаггүй дайжих замтай байна.

(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, хальтирдаггүй дайжих замтай байна.

D.2.6. Ослын гэрэлтүүлэг

(a) Ослын гэрэлтүүлгийн системд шаардлагатай гэрэл бүр нь:

- (1) асаах-ON, унтраах-OFF болон бэлэн-ARMED гэсэн байрлал бүхий бүхээгийн удирдлагын тоноглолтой байх;
- (2) дараах байрлалаас гараар ажиллуулах боломжтой байх:
 - (i) тухайн нисэх багийн гишүүдийн хэвийн суугаа байрлалаас;
 - (ii) тухайн зорчигчийн бүхээгт, бүхээгийн ажилтны хэвийн суудлаас хялбар хүрэх байрлалаас;
- (3) тухайн гар удирдлагыг санаандгүй ажиллуулахаас хамгаалах хэрэгсэлтэй байх;
- (4) бэлэн, эсхүл асаалттай байрлалд байгаа үед их бие босоо огтлолоор хуваагдахаас бусад тохиолдолд онгоцны үндсэн цахилгаан тэжээл тасрахад асаалттай хэвээр байх, эсхүл асах;
- (5) ослын буултын дараа гадна орчны хүндрэлтэй нөхцөлд минимум 10 минут шаардлагатай гэрэлтүүлгийн түвшинг хангасан байна.

(b) Бүхээг дэх хүмүүсийг газарт буухад туслах хэрэгслийн бүрэлдэхүүн хэсэг болох гэрэл нь дараах тохиолдолд энэ зүйлийн (a)-гийн шаардлагыг хангахгүй байж болно, хэрэв:

- (1) зөвхөн нэг туслах хэрэгсэлд үйлчилдэг;
- (2) туслах хэрэгсэл дэлгэгдэхэд автоматаар идэвхждэг;
- (3) онгоцны үндсэн ослын гэрэлтүүлгийн системээс тусдаа, бие даасан бол.

D.2.7. Ослын дотоод гэрэлтүүлэг

Онгоц бүр дараах ослын гэрэлтүүлгийн системтэй байна:

- (1) үндсэн гэрэлтүүлгийн системээс ангид, бие даасан тэжээлийн эх үүсвэртэй байх;
- (2) зорчигчийн бүхээгийн үндсэн замын гол шугамын дагуу 1м тутамд, сандлын тохойвчны өндөрт хэмжсэн дундаж гэрэлтүүлгийн хүч нь 0.05 foot-candles-ээс багагүй байх;
- (3) гарц бүрийн тэмдэг, тэмдэглэгээг гэрэлтүүлдэг байх;
- (4) шалны ойролцоох ослын дайжих замын тэмдэглэгээг багтаасан байх.

D.2.8. Ослын гадна гэрэлтүүлэг

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, онгоц бүр нь 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан, ослын гадна гэрэлтүүлэгтэй байна.

(b) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, ослын гадна гэрэлтүүлэгтэй байна.

D.2.9. Ослын гарцны дотор тэмдэглэгээ

(a) Ослын гарц бүрийг болон тэдгээрт хүрэх арга хэлбэрийг дараах байдлаар ойлгомжтой бөгөөд тод харагдахуйц тэмдэглэсэн байна:

- (1) түүний таних тэмдэг болон байрлал нь бүхээгийн өргөнтэй тэнцэх зайнаас танигдахуйц;
- (2) түүнийг нээх арга хэлбэрийг агуулсан.

(b) Ослын гарц бүрийн байрлалыг, зорчигчийн үндсэн замын дагуу ойртон ирж буй бүхээг дэх хүмүүст харагдахуйц тэмдгээр дараах байдлаар тэмдэглэсэн байна:

- (1) далавчин дээрх ослын гарц бүрийн ойролцоо, гадагшаа гарах замын дээд талд;
- (2) шалны түвшний ослын гарц бүрийн хажууд, хэрэв тухайн тэмдгээс хоёр гарц хоёулаа хялбар харагдах боломжтой бол хоёр гарцыг нэг тэмдгээр тэмдэглэж болно;
- (3) зорчигчийн бүхээгийн урд болон хойд хэсгийн харагдах орчныг хязгаарласан хөндлөвч, эсхүл тусгаарлагч бүр дээр, тэдгээрт халхлагдсан ослын гарцуудыг заасан тэмдэг тавина.

(c) Энэ зүйлийн (d)–д зааснаас бусад тохиолдолд, онгоц бүр нь 1972 оны 04 сарын 30-нд хүчинтэй болсон тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлагыг хангасан, ослын гарцны тэмдэг тэмдэглэгээтэй байна.

(d) 1972 оны 05 сарын 01, эсхүл түүнээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь тухайн онгоцны маягийн гэрчилгээжүүлэлтийн шаардлага хангасан, ослын гарцны тэмдэг тэмдэглэгээтэй байна.

(e) Ослын гарцны тэмдэг тэмдэглэгээ бүр нь минимум 250 микроламберт гэрлийн тодройцтой байна.

D.2.10. Ослын гарцны гадна тэмдэглэгээ

Гадна талаас нь ажиллуулдаг ослын гарц бүрийг их биений гадна талд дараах байдлаар тэмдэглэсэн байх ёстой:

- (1) гарцыг 50 мм өргөнтэй үргэлжилсэн өнгөт зурвасаар дараах байдлаар тойруулан зурсан байх:
 - (i) хажуугийн гадаргуугаас ялгарч харагдуулахын тулд өөр өнгө ашиглаж;
 - (ii) гарцны ирмэг дээр, гарцны эргэн тойрны гадаргуу дээр, эсхүл гарцны ирмэг болон эргэн тойрны гадаргууд хоёулан дээр нь хувааж;
- (2) их биений хажуу гадаргууд байрлаагүй гарцны хувьд:
 - (i) гаднаас нээх арга хэлбэр болон холбогдох зааварчилгааг улаан өнгөөр, эсхүл улаан өнгө нь дэвсгэрийн өнгөнөөс хангалттай ялгарч харагдахгүй бол тод гялалзсан шар өнгөөр тэмдэглэсэн байх;
 - (ii) хэрэв нээх гарц нь их биений зөвхөн нэг талд байгаа бол, нээх зааварчилгааг их биений хоёр талд байрлуулсан байх.

D.3. Ариун цэврийн өрөөний галын хамгаалалт

(a) Ариун цэврийн өрөө бүрийг тод харагдахуйцаар, дараах байдлаар тэмдэглэсэн байх ёстой:

- (1) ариун цэврийн өрөөнд тамхи татахыг хориглосон тэмдгийг хаалганы хоёр талд;
- (2) ариун цэврийн өрөөний цаасны сав, эсхүл хогийн савны таг бүр дээр “саванд тамхи хаяхыг хориглосныг” анхааруулсан тэмдэг.

(b) Тамхи татах зориулалтгүй онгоцноос бусад онгоцны ариун цэврийн өрөө бүр нь хаалганы гадна талд, эсхүл түүний ойролцоо өөртөө хураадаг, үнсний салдаг савтай байна.

(c) Ариун цэврийн өрөө бүрийн цаасны сав, эсхүл хогийн сав бүр дараах шаардлагыг хангасан байна:

- (1) галыг тухайн савандаа барих жийрэг бүхий тагтай байх;
- (2) хогийн саванд гал гарсан тохиолдолд автоматаар цацагдахаар зохион бүтээгдсэн, дотор нь суурилуулсан гал унтраагууртай байх.

(d) Ариун цэврийн өрөө бүрийг дараах утаа мэдрэгч, эсхүл түүнтэй дүйцэх хэрэгслээр тоноглосон байна:

- (1) тухайн бүхээгт анхааруулах гэрлэн дохио өгдөг; эсхүл
- (2) багийн гишүүд нислэгийн бүх үе шатанд хялбар илрүүлэх боломжтой анхааруулах гэрлэн, эсхүл дуут дохио өгдөг.

D.4. Бүхээгийн доторлогооны материал

(a) 1958 оны 01 сарын 01, эсхүл түүнээс өмнө маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь бүхээгийн дотор тоноглолын анхны томоохон бүрэн солилтын үед багийн гишүүд, эсхүл зорчигчийн ашигладаг бүхээг бүрт 1972 оны 04 сарын 30-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-ын шаардлага хангасан материал хэрэглэнэ.

(b) Энэ зүйлийн (c)–д зааснаас бусад тохиолдолд, 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь:

- (1) хэрэв 1988 оны 08 сарын 20-нд, эсхүл түүнээс хойш, гэхдээ 1990 оны 08 сарын 20-ноос өмнө үйлдвэрлэгдсэн бол багийн гишүүд, эсхүл зорчигчийн ашигладаг бүхээг бүрт 1993 оны 03 сарын 29-өөс хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан дулаан ялгаруулалтын түвшний тестийн шаардлагыг хангасан материалыг дараахаас бусад тохиолдолд хэрэглэнэ:
 - (i) материалын дээжийг туршсан эхний 2 минутын хугацаанд ялгаруулах нийт дулааны хэмжээ нь 100 киловатт / минут м²-аас хэтрэхгүй байх;
 - (ii) дулаан ялгаруулалтын дээд хэмжээ нь 100 киловатт / м²-аас хэтрэхгүй байх;
- (2) хэрэв 1990 оны 08 сарын 20, эсхүл түүнээс хойш үйлдвэрлэгдсэн бол, багийн гишүүд, эсхүл зорчигчийн ашигладаг бүхээг бүр нь 1993 оны 03 сарын 29-өөс

хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан дулаан ялгаруулалтын түвшний болон утааны тестийн шаардлага хангасан байх;

(3) бүхээгийн дотор тоноглолын анхны томоохон бүрэн солилтын үед багийн гишүүд, эсхүл зорчигч ашигладаг бүхээг бүрт 1993 оны 03 сарын 29-өөс хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-ын шаардлага хангасан материал хэрэглэх.

(c) 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоц бүр нь нислэгийн бүхээгийн суудлаас бусад бүх суудлын зөөлөвчийг 1984 оны 11 сарын 26-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR-25-д заасан галаас хамгаалах шаардлагыг хангасан зөөлөвчөөр тоноглоно.

D.5. Ачаа болон тээшний бүхээг

(a) 1958 оны 01 сарын 01-ээс хойш маягаар гэрчилгээжсэн онгоцны хувьд:

(1) 1986 оны 06 сарын 16-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857–д заасан C, эсхүл D ангиллын ачаа, эсхүл тээшний бүхээгийн эзлэхүүн нь 200 куб фут-ээс дээш бол, тааз болон хана доторлогооны хавтангууд нь дараах материалаар хийсэн байх шаардлагатай:

- (i) шилэн даавуугаар бэхжүүлсэн композит (glass fibre reinforced resin); эсхүл
- (ii) АНУ-ын FAR 25-ын Appendix F, part III-д заасан тестийн шаардлага хангасан материал; эсхүл
- (iii) 1989 оны 03 сарын 20-оос өмнө зөвшөөрөгдсөн доторлогоо бол хөнгөн цагаан;

(2) 2008 оны 01 сарын 01-ээс эхлэн:

- (i) 1986 оны 06 сарын 16-аас хүчинтэй болсон АНУ-ын FAR 25.857–д заасан D ангиллын ачаа, эсхүл тээшний бүхээг нь эзлэхүүнээс үл хамааран 1998 оны 02 сарын 17-оос хүчинтэй АНУ-ын FAR 25.857(c) болон 1998 оны 02 сарын 17-оос хүчинтэй FAR 25.858-д заасан C ангиллын бүхээгийн шаардлагыг хангасан байх шаардлагатай; эсхүл
- (ii) хэрэв тухайн онгоц нь зөвхөн ачаа (all-cargo)-ны зориулалтаар ашиглагдаж байгаа бол, D ангиллын ачааны бүхээг нь 1998 оны 02 сарын 17-оос хүчинтэй АНУ-ын FAR 25.857(e)-д заасан E ангиллын ачааны бүхээгийн шаардлагыг хангасан байж болно.

(b) Энэ зүйлийн (a)(1)-ийн зорилгоор, “доторлогоо” (liner) гэсэн нэр томъёо нь галыг аюулгүй тогтоон барих доторлогооны чадварт нөлөөлөх холбоос, эсхүл түгжээ зэрэг загварын аливаа хэв шинжийг багтаана.

Хавсралт Е — Нисдэг тэрэг

Нисдэг тэрэгний гэрчилгээжүүлэлтийн нэмэлт НТЧ-ын шаардлага нь Хавсралт В-д зааснаас гадна дараах зүйлийг агуулна:

Е.1. Хаалга болон гарц

Агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаар зорьж буй нисдэг тэрэг бүр нь дараах гадна хаалга болон гарцтай байна:

- (1) дотор ба гадна талаас нь нээх боломжтой;
- (2) суудал, суудлын түшлэг, эсхүл бусад тоног төхөөрөмжөөр халхлагдаагүй;
- (3) дараах хэрэгсэлтэй байх:
 - (i) нислэгийн үед механик гэмтлийн үр дүнд, эсхүл хүмүүс санамсаргүй нээхээс сэргийлсэн түгжээтэй;
 - (ii) тухайн хаалгыг нисдэг тэрэгний ачилт болон буулгалтад ашигладаг бол, хаалга бүрэн хаагдаагүй болон түгжигдээгүй байгаа нь багийн гишүүдэд ил харагдахаар байна.

Е.2. Нүүлгэн гаргах болон гарах гарц

Е.2.1. Ослын гарцны тэмдэглэгээ

Агаарын тээврийн үйл ажиллагаанд ашиглахаар зорьж буй нисдэг тэрэгний ослын гарц бүрийг болон түүнд хүрэх арга хэлбэрийг дараах байдлаар тод харагдахуйц тэмдэглэсэн байна:

- (1) таних тэмдэг болон байрлал нь бүхээгийн өргөнтэй тэнцэх зайнаас танигдахуйц байх;
- (2) хаалгыг нээх арга хэлбэрийг агуулсан байх.

--oOo--